



“ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР”

ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР

Найрамдал талбай, Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61027

Утас: 976 (757) 7 35 01, Факс: (976) 7035 3002,

Цахим шуудан: info@erdenetmc.mn,

Цахим хаяг: www.erdenetmc.mn

2024.05.02 № СЭ-112-12/2483

танай _____-ны № _____-т

Захиалагчийн шийдвэр гаргах хугацааг
сунгах тухай

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас зарласан “Ширмэн хаалтууд*” нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ЭҮТӨҮГ/20240102130 дугаартай тендерт оролцсон Апейро ХХК-аас Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсэг, Сангийн яамны 2023 оны А/253 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам” (цаашид “журам” гэх)-ын 4.1-д заасны дагуу гомдол гаргасан.

Тус гомдлын дагуу Сангийн яам 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 03/3221 дугаартай албан бичгээр Сангийн сайдын 2023 оны А/253 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам”-ын 5.9-т заасныг хэрэгжүүлж, холбогдох арга хэмжээ авах гэсэн шийдвэр гаргасан тул хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсгийг үндэслэн захиалагчийн шийдвэр гаргах хугацааг ажлын 15 хоногийн хугацаагаар сунгаж байгааг мэдэгдье.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХУДАЛДАН
АВАХ АЖИЛЛАГААНЫ БОДЛОГЫН
ГАЗРЫН ДАРГА



С.ЭНХМАНДАХ

612407010028